



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 09

Мандалговь

О.Ганбаатарыг Адаацаг сумын ЗДТГ-ын
Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Оч-Эрдэнэ овогтой Ганбаатар 45.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа О.Ганбаатарын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын
Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн О.Ганбаатарын тухай дүгнэлт**

1. О.Ганбаатар нь 1995 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 27 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2013-2017 онд Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийг Мал зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. О.Ганбаатарын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ